

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

2024 оны 05 сарын 06-ны өдөр

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төсөл:	Санал: Нэмэх, Өөрчлөх, Хасах	Тайлбар:
11.3. Энэ хуулийн 13.3-т заасан журмыг аймгийн саналыг авсны үндсэн дээр Нийслэлийн Засаг дарга боловсруулна.	Өөрчлөх: Энэ хуулийн 13.3-т заасан журмыг аймаг, нийслэлийн саналыг нэгтгэн авсны үндсэн дээр Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж Засгийн газарт өргөж барьж батлуулна.	Учир нь энэ хуулийн 13.3. дахь хэсэгт “Энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд хувийн хэвшлээс санаачлах, төсөлд урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээ хийх, үнэлэх, төслийг тодорхойлж, хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээ байгуулах, хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах, түншлэлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, гэрээний биелэлт, төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавихтай холбогдсон журмыг Засгийн газар батлах бөгөөд журмын дагуу түншлэлийн төслийг хэрэгжүүлнэ.” Гэж заасан байдаг бөгөөд уг журмын саналыг боловсруулах үүргийг Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.